



**БАЯНХОНГОР АЙМГИЙН  
БАЯНЦАГААН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2023 оны 02 сарын 13 өдөр

Дугаар 9/04

Баянбулаг

Тэмээний баяр зохион  
байгуулах тухай

Монгол улсын засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.11, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2 дугаар хэсгийн 2.1.5, сумын нийгэм, эдийн засгийг хөгжүүлэх 2023 оны үндсэн чиглэлийн 3, 28 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Тус сумд 2023 оны 02 дугаар сарын 19-ний өдөр болох “Тэмээний баяр”-ыг зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Д.Энхтөр (Хөдөө аж ахуйн тасгийн даргын үүрэг гүйцэтгэгч)

Гишүүд Б.Батхонгор (Мал эмнэлгийн тасгийн дарга)

Г.Өлзий-Орших (Баянбулаг багийн засаг дарга)

Б.Цэрэнпунцаг (Цэцэн багийн засаг дарга)

С.Намжилмаа (Хөдөө аж ахуйн тасгийн мэргэжилтэн)

2.Тэмээний баяр зохион байгуулах удирдамжийг хавсралтаар баталсугай.

3.Уг арга хэмжээ зохион байгуулахтай холбоотой гарах 3,211,000 (Гурван сая хоёр зуун арван нэг мянга) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг Санхүү албаны дарга, нягтлан бодогч нарт зөвшөөрсүгэй.

ДАРГА



Н.ГАНСҮХ

642201199

2023 on zahiramj



Баянцагаан сумын Засаг даргын 2023 оны 02  
дүгээр сарын 13-ны өдрийн 1/04 дугаар  
захирамжийн хавсралт

БАЯНХОНГОР АЙМГИЙН БАЯНЦАГААН СУМЫН  
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

УДИРДАМЖ

2023 оны 02 дугаар сарын 13

Баянбулаг

“Тэмээний баяр зохион байгуулах тухай”

**Зорилго:** Тэмээ маллагаа, уналага эдэлгээний уламжлалт өв соёлыг сурталчлах, хөдөлмөрийг үнэлэх, урамшуулах залуу хойч үедээ өвлүүлэн үлдээх, тэмээн сүргийн тоо толгойг тогтвортой өсгөх, ашиг шим болон тэмээний үнэлэмжийг нэмэгдүүлэхэд оршино.

**Хамрах хүрээ:** Нээлттэй

**Хугацаа:** 2023 оны 02 дугаар сарын 19-нд 09:00 цагт Ягаан дэлийн хоолойд болно.

**Явагдах төрөл:**

- Хурдан атан тэмээний уралдаан (Монгол)
- Хурдан тайлаг (Шилбэ, хөгширөх нас)
- Хурдан торомны уралдаан (Монгол) эр
- Сайхан тэмээ шалгаруулах (Ганцаарчилсан төрөл)
- Шилмэл буур шалгаруулах
- Шилмэл ингэ шалгаруулах

**Шалгаруулах журам:**

- Хурдан атан тэмээний уралдаан эхний 5 байр. (Монгол тэмээ, эрлийз тэмээг ялгахдаа үүлдэрлэг байдлыг онцгой анхаарч ялгана.)
- Хурдан тайлаг (Шилбэ, хөгширөх нас) Эхний 5 байр.
- Хурдан торомны уралдаан эхний 5 байр (Зөвхөн монгол эр тором уралдана)
- Сайхан тэмээ ганцаарчилсан төрөл шалгаруулах: Эхний 5 байр (Сайхан тэмээний үндсэн шинж, уналга, эдэлгээнд сургасан байдал, эдлэл хэрэглэл зэргийг харгалзана.)
- Шилмэл буур шалгаруулах: Эхний 5 байр
- Шилмэл ингэ шалгаруулах: Эхний 3 байр (Шилмэл хээлтэгчийн үндсэн шинжийг харгалзана. Биеийн ерөнхий харьцаа, ноос, галбир төрх, Сүүгээр гэсэн 2 төрлөөр шалгаруулна.)

**Шагнал урамшуулал**

Тэмээний уралдаан (атан тэмээ, тайлаг, тором)

1-р байр Алтан медаль, өргөмжлөл, 150,000 төгрөг

2-р байр Мөнгөн медаль, өргөмжлөл, 120,000 төгрөг

3-р байр Хүрэл медаль, өргөмжлөл, 100,000 төгрөг

4-р байр Хүрэл медаль, өргөмжлөл, 100,000 төгрөг

5-р байр Хүрэл медаль, өргөмжлөл, 100,000 төгрөг



Сайхан тэмээ (Ганцаарчилсан төрөл)

- 1-р байр Алтан медаль, өргөмжлөл, 100,000 төгрөг
- 2-р байр Мөнгөн медаль, өргөмжлөл, 80,000 төгрөг
- 3-р байр Хүрэл медаль, өргөмжлөл, 60,000 төгрөг
- 4-р байр Хүрэл медаль, өргөмжлөл, 60,000 төгрөг
- 5-р байр Хүрэл медаль, өргөмжлөл, 60,000 төгрөг

Шилмэл буур

- 1-р байр Алтан медаль, өргөмжлөл, 100,000 төгрөг
- 2-р байр Мөнгөн медаль, өргөмжлөл, 80,000 төгрөг
- 3-р байр Хүрэл медаль, өргөмжлөл, 60,000 төгрөг
- 4-р байр Хүрэл медаль, өргөмжлөл, 60,000 төгрөг
- 5-р байр Хүрэл медаль, өргөмжлөл, 60,000 төгрөг

Шилмэл ингэ (Сүүтэй ингэ, сайхан ингэ)

- 1-р байр Алтан медаль, өргөмжлөл, 100,000 төгрөг
- 2-р байр Мөнгөн медаль, өргөмжлөл, 70,000 төгрөг
- 3-р байр Хүрэл медаль, өргөмжлөл, 50,000 төгрөг

-----oOo-----